



МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
НИЙТ ШҮҮГЧИЙН ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ

2026 оны 04 сарын 17 өдөр

Дугаар 27

Улаанбаатар хот

Хөгжлийн хөтөлбөр намын
шинэчилсэн дүрмийг бүртгэх тухай

Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааныг Ерөнхий шүүгч Д.Ганзориг даргалж, Танхимын тэргүүн Д.Мөнхтуяа, Ч.Хосбаяр, шүүгч Б.Амарбаясгалан, Г.Банзрагч, Д.Батбаатар, Б.Батцэрэн, Н.Батчимэг, Э.Золзаяа, П.Соёл-Эрдэнэ, С.Соёмбо-Эрдэнэ, Б.Ундрах, Б.Цогт, Ц.Цогт, Д.Цолмон, Х.Эрдэнэсүвд нарын бүрэлдэхүүнтэй хийсэн хуралдаанаар,

Хөгжлийн хөтөлбөр намын шинэчилсэн дүрмийг бүртгүүлэх тухай өргөдлийг танхимын тэргүүн Д.Мөнхтуяа танилцуулснаар хэлэлцээд

ТОДОРХОЙЛОХ нь:

Хөгжлийн хөтөлбөр намын дарга О.Заяагаас “Намын дүрэм, мөрийн хөтөлбөрийг батлах үйл ажиллагаанд гаргасан зөрчлийг арилгаж, намын дүрмээ холбогдох хуульд нийцүүлэн өөрчлөлтийг бүртгүүлэхээр дахин хандаж байгаа тул хуульд заасан журмын дагуу шийдвэрлэж, бүртгэж өгнө үү” гэсэн өргөдлийг 180 хуудас баримт, 1 ширхэг флаш, Өдрийн сонины хамт 2026 оны 03 дугаар сарын 20-ны өдөр Улсын дээд шүүхэд ирүүлсэн байна.

Дээрх өргөдөл, хавсралт баримтуудыг Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга) болон Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 06 дугаар тогтоолоор баталсан “Улс төрийн намын бүртгэл хөтлөх журам”-ын 2.5-д заасны дагуу шалгах ажиллагааг хэрэгжүүлсэн ба сонсох ажиллагааны явцад нэмэлтээр 199 хуудас баримт бичиг, 1 ширхэг флаш, 1 ширхэг өдрийн сонин ирүүлснийг шалгаад, журмын 6.6-д зааснаар нийт шүүгчийн хуралдаанаар хэлэлцэв.

ҮНДЭСЛЭХ нь:

Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 2 дугаар зүйлд “Нам өөрийн дүрэм, хөтөлбөр, дотоод зохион байгуулалтыг Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-тай нийцүүлэх арга хэмжээг 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор авч хэрэгжүүлэх бөгөөд уг өөрчлөлтийг Улсын дээд шүүхэд 30 хоногийн дотор хүргүүлнэ” гэж заасан.

Хөгжлийн хөтөлбөр нам нь өөрийн намын хөтөлбөр, дүрмийг шинэчлэн бүртгүүлэхээр хуульд заасан дээрх хугацааны дотор буюу Улсын дээд шүүхэд 2025

оны 12 дугаар сарын 19-ний өдөр өргөдөл ирүүлсэн боловч хуульд заасан шаардлагыг хангаагүй тодорхой алдаа, зөрчилтэйн улмаас тус намын дүрмийн өөрчлөлтийг бүртгээгүй, буцаасан байна.

Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн хуралдаанаар зөрчлөө зассаны үндсэн дээр дахин нэг удаа 60 хоногийн дотор намын дүрмээ бүртгүүлэх боломжийг олгосны дагуу тухайн нам нь шүүхээс тогтоосон хугацаанд өргөдлөө дахин ирүүлсэн, ингэхдээ Улсын дээд шүүхийн тогтоолд заасан алдаа зөрчлийг засаж, Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-д заасан шаардлагад нийцүүлэн дүрмээ шинэчлэн баталж ирүүлсэн байх тул Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаас Хөгжлийн хөтөлбөр намын шинэчилсэн дүрмийг бүртгэж шийдвэрлэв.

Нэг. Намын удирдах дээд байгууллага болох Их хурлыг зарлан хуралдуулсан процессын талаар:

1.1. Хөгжлийн хөтөлбөр намын дүрэм (2015 он)-ийн 8.1-д “Зуут мянгатын бага хурал нь НАШБ-с сонгогдсон төлөөлөгчдөөс бүрдэнэ ...”, 8.2-т “Бага хурал нь дараах эрх үүрэгтэй” гээд б/-д “ХХН-ын Их хурлын төлөөлөгчдийг сонгоно”, 9.1-ийн в/-д “Намын Их хурал ХХН-ын бага хурлыг сонгон байгуулна. ХХН-ын Бага хурал намын гишүүдээс сонгогдсон 9 ба түүнээс дээш гишүүнтэй байна”, 9.3-т “Их хурлын хуралдах тов, төлөөлөгчдийн тоо, сонгох журмыг намын Бага хурал батлан гаргана ...”, 10.1-ийн г/-д “Намын Бага хурал нь намын Удирдах зөвлөлийг 5 хүний бүрэлдэхүүнтэй сонгоно”, 10.3-т “Намын Бага хурлыг шаардлагатай үед намын Удирдах зөвлөлөөс зарлан хуралдуулна ...” гэж тус тус заажээ.

1.2.Өргөдөлд хавсаргаж ирүүлсэн баримтуудаас үзвэл, тус намын Бага хурлын 2015 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 03 дугаар тогтоолоор Удирдах зөвлөлийн 5 гишүүнийг баталсан байх бөгөөд уг зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 08 дугаар тогтоолоор намын төлөөллийн төв байгууллага болох Бага хурлыг 2026 оны 02 дугаар сарын 09-ний өдөр зарлан хуралдуулсан, тус Бага хуралд 35 гишүүн оролцохоос 19 гишүүн оролцсон, эдгээр гишүүдийн нэрсийг Улсын дээд шүүхэд хадгалагдаж буй намын хувийн хэргээс шалгахад 2015 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 2 дугаар Их хурлын 07 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан гишүүдийн нэрстэй таарсан тул хуралд оролцох эрх бүхий этгээдүүд оролцсон гэж үзэхээр байна.

1.3.Улмаар Бага хурлын 2026 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн 03 дугаар тогтоолоор намын Их хурлыг 2026 оны 02 дугаар сарын 27-ны өдөр зохион байгуулахаар товлон зарлаж, Их хурлын төлөөлөгчийг 60 байхаар тогтоож, хурлын тов, зохион байгуулагдах газрыг Өдрийн сонины 2026 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн №061(7913) дугаарт нийтлэн мэдээлжээ.

1.4.2026 оны 02 дугаар сарын 27-ны өдөр танхимын хэлбэрээр зохион байгуулагдсан тус намын Их хуралд 60 төлөөлөгч оролцсоноос 52 төлөөлөгчийг 6 дүүргийн намын хорооноос, 8 төлөөлөгчийг аймгийн намын хорооноос тус тус сонгон оролцуулсан нь ирцийн бүртгэл, фото зураг, дүрс бичлэг, бусад баримтаар тогтоогдож байх тул тухайн хурлыг хуралдуулсан процесс зөрчилгүй байна.

Хоёр. Намын шинэчилсэн дүрмийг баталсан талаар:

2.1. Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-ийн 17 дугаар зүйлийн 17.2-т “Намын удирдах дээд байгууллага дараах асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ: 17.2.1. намын дүрэм, хөтөлбөрийг батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах” гэж, Хөгжлийн хөтөлбөр намын дүрэм (2015 он)-ийн 9.1-д “Намын дээд байгууллага болох намын Их хурал нь намын амьдралын аль ч асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж болох бөгөөд дараах асуудлыг өөрийн бүрэн эрхэд хадгална”, а/-д “Намын мөрийн хөтөлбөр дүрмийг хэлэлцэн батлах өөрчлөлт оруулах” гэж тус тус заажээ.

Үүний дагуу тухайн намын Их хурал 2026 оны 02 дугаар сарын 27-ны өдөр дахин хуралдаж, дүрмийг шинэчлэн баталсан тухай 03 дугаар тогтоолыг хуралдаанд оролцсон 60 төлөөлөгчийн 100 хувийн саналаар гаргасан нь мөн өдрийн хуралдааны тэмдэглэл, Тооллогын комиссын 02 дугаар тогтоол, өргөдөлд хавсарган ирүүлсэн бусад баримтаар тогтоогдож байна.

Улсын дээд шүүхийн 2026 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 02/216 дугаар албан бичгээр Хөгжлийн хөтөлбөр намын дүрмийн өөрчлөлтийг бүртгэхээс татгалзаж буцаахдаа “... Их хурлыг товлон зарлах үйл ажиллагаа нь дүрэмдээ нийцээгүй, сахилгын шийтгэлийн эсрэгцсэн хэм хэмжээг нэг зохицуулалтад оруулсан, хугацаа, шийдвэр гаргах журам, сахилгын шийтгэлгүйд тооцох хөөн хэлэлцэх хугацаа тодорхойгүй, гишүүний татварын хэмжээг тодорхой заагаагүй, намын бүтцийн байгууллагуудын бүрэн эрхийн хугацаа, хуралдуулах, шийдвэр гаргах журам, эдгээр байгууллагад аль нэг хүйсийн төлөөлөл нэр дэвшихэд 30 хувь, бүрэлдэхүүнд 40 хувь байх хуулийн шаардлага, жендерийн тэгш байдлыг хангах, аливаа асуудлыг олонхоор шийдвэрлэх, гишүүдийн оролцоог хангах, бүтцийн байгууллагын бүрэлдэхүүний орон гарсан тохиолдолд тэдгээрийг аль байгууллагаас хэрхэн сонгохтой холбоотой зохицуулалт, санхүүгийн асуудал хариуцсан ажилтан болон аудитортой холбоотой эрх зүйн байдал, эрх, үүрэг, хариуцлага, сонгох томилох журмыг дүрэмд тусгаагүй, намын нэр өөрчлөх эрхийг төлөөллийн төв байгууллагад олгосон, хяналтын байгууллагын хараат бус байдал, маргаан шийдвэрлэх журмыг тусгаагүй, бүрэлдэхүүний тоо тодорхойгүй, дүрмийн зарим заалт нь хоорондоо зөрчилтэй, намын даргыг чөлөөлөх, огцруулах үндэслэлийг тусгаагүй, хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.8, 15.2.9, 15.2.10, 19.1, 26.4, 26.5, 27.13, 41.3, 42.4-т заасан намын дүрмээр зайлшгүй зохицуулах асуудлуудыг орхигдуулсан” зэрэг алдаа зөрчлийг засах шаардлагатайг заасан.

Хөгжлийн хөтөлбөр намын 2026 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн Их хурлаас баталсан шинэчилсэн дүрэмд дээрх алдаа, зөрчлийг зассан, харин дүрмийн зарим заалтын агуулга нь тодорхой бус, ойлгомжгүй, техникийн шинжтэй алдаатай байсныг 2026 оны 03 дугаар сарын 31-ний өдөр сонсох ажиллагаа явуулж тодруулсан, үүнтэй холбогдуулан тус намын Бага хурал 2026 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр хуралдаж, намын дүрэмдээ нэмэлт, өөрчлөлт оруулж, холбогдох баримтыг шүүхэд хамт ирүүлсэн байна.

Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-ийн 17 дугаар зүйлийн 17.4-т “Намын төлөөллийн төв байгууллагын гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь санал гаргавал намын дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж болно. Энэ нэмэлт, өөрчлөлт нь намын дүрмийн гуравны

нэгээс хэтрэхгүй байна” гэж, Хөгжлийн хөтөлбөр намын дүрэм (2015 он)-ийн 10.1-д “ХХН-ын Бага хурал нь дараах эрх үүрэгтэй байна”, ё/-д “Зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд намын Бага хурлаар намын дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулж болно. Намын дүрэмд оруулах нэмэлт, өөрчлөлтийг хуралд оролцсон гишүүдийн дийлэнх олонхын саналаар шийдвэрлэнэ” гэж тус тус заасан байх тул намын Удирдах зөвлөлийн 2026 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 02 дугаар тогтоолоор ээлжит бус Бага хурлыг 2026 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр зарлан хуралдуулж, хуралдаанд 18 гишүүн оролцож, намын дүрэмд өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэж, 100 хувийн саналаар дэмжин баталсан нь хууль болон намын дүрмийг зөрчөөгүй гэж үзлээ.

Түүнчлэн, Хөгжлийн хөтөлбөр намын 2026 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн Их хурлын 03 дугаар тогтоолоор баталсан намын шинэчилсэн дүрэм нь 19 бүлэг, 199 заалт, 209 дэд заалт байсан, үүний 31 заалт, дэд заалт буюу 0.07 хувьд нь Бага хурлын 2026 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 10 дугаар тогтоолоор нэмэлт, өөрчлөлт оруулсан нь хуулийн 17 дугаар зүйлийн 17.4-т заасантай нийцсэн байна.

Иймд, Хөгжлийн хөтөлбөр намын 2026 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн Их хурлын 03 дугаар тогтоолоор баталсан намын шинэчилсэн дүрэмд Бага хурлын 2026 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 10 дугаар тогтоолоор нэмэлт, өөрчлөлт оруулсан нь Улс төрийн намын тухай хуулийн 15 дугаар зүйлд заасан намын дүрэмд тавигдах нийтлэг шаардлага болон намын дүрмээр тусгайлан зохицуулах асуудлыг тусгасан байх тул шинэчилсэн дүрмийг бүхэлд нь бүртгэж шийдвэрлэв.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8.8, 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэгт заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1.Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-ийн 15 дугаар зүйлийн 15.3, 15.5 дахь заалтыг баримтлан Хөгжлийн хөтөлбөр намын шинэчилсэн дүрмийг бүртгэсүгэй.

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ,
ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

Д.ГАНЗОРИГ

ТАНХИМЫН ТЭРГҮҮН

Д.МӨНХТУЯА